| 8   | Зарласан ногдол ашиг                            | -                               | -                     | -                 | -                                      |
| 9   | Тайлант үеийн үр дүн                            | -                               | -                     | (8,483,142.31)    | (8,483,142.31)                         |
| 10  | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | -                               | -                     | 48,759,672.21     | 48,759,672.21                          |
| 11  | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл             | -                               | -                     | 48,759,672.21     | 48,759,672.21                          |
| 12  | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | -                               | -                     | -                 | -                                      |
| 13  | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | -                               | -                     | 48,759,672.21     | 48,759,672.21                          |
| 14  | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт бууралт | -                               | -                     | -                 | -                                      |
| 15  | Үндсэн хөрөнгийн есөлт бууралт                  | -                               | -                     | -                 | -                                      |
| 16  | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз   | -                               | -                     | -                 | -                                      |
| 17  | Өмчид гарсан өөрчилөлт                          | -                               | -                     | -                 | -                                      |
| 18  | Зарласан ногдол ашиг                            | -                               | -                     | -                 | -                                      |
| 19  | Тайлант үеийн үр дүн                            | -                               | -                     | 1,662,177.86      | 1,662,177.86                           |
| 20  | 2024 оны 12 р сарын 31-нээрх үлдэгдэл           | -                               | -                     | 50,421,850.07     | 50,421,850.07                          |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код    | Үзүүлэлт                                                 | Төлөвлөгөө     | Гүйцэтгэл      | Зөрүү           | Хувь  |
|--------|----------------------------------------------------------|----------------|----------------|-----------------|-------|
| II     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | 145,100,800.00 | 121,529,458.59 | (23,571,341.41) | 83.8  |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ                                            | 145,100,800.00 | 121,529,458.59 | (23,571,341.41) | 83.8  |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 144,900,800.00 | 121,329,458.59 | (23,571,341.41) | 83.7  |
| 2101   | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 107,528,300.00 | 90,775,794.22  | (16,752,505.78) | 84.4  |
| 210101 | Үндсэн цалин                                             | 59,185,000.00  | 56,161,824.16  | (3,023,175.84)  | 94.9  |
| 210102 | Нэмэгдэл                                                 | 36,990,800.00  | 24,571,570.06  | (12,419,229.94) | 66.4  |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт                                    | 3,991,000.00   | 2,463,000.00   | (1,528,000.00)  | 61.7  |
| 210104 | Урамшуулал                                               | 7,361,500.00   | 7,579,400.00   | 217,900.00      | 103.0 |
| 2102   | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 13,441,000.00  | 11,472,064.37  | (1,968,935.63)  | 85.4  |
| 210201 | Тэтгэврийн даатгал                                       | 9,139,900.00   | 8,048,478.58   | (1,091,421.42)  | 88.1  |
| 210202 | Тэтгэмжийн даатгал                                       | 1,075,300.00   | 829,014.69     | (246,285.31)    | 77.1  |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал                                        | 537,600.00     | 403,607.36     | (133,992.64)    | 75.1  |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал                                     | 537,600.00     | 374,916.36     | (162,683.64)    | 69.7  |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал                                    | 2,150,600.00   | 1,816,047.38   | (334,552.62)    | 84.4  |
| 2103   | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 6,556,900.00   | 5,127,000.00   | (1,429,900.00)  | 78.2  |
| 210304 | Байрны түрээс                                            | 6,556,900.00   | 5,127,000.00   | (1,429,900.00)  | 78.2  |
| 2104   | Хангамж, бараа материалын зардал                         | 10,676,500.00  | 8,320,500.00   | (2,356,000.00)  | 77.9  |
| 210401 | Бичиг хэрэг                                              | 849,100.00     | 873,850.00     | 24,750.00       | 102.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун                                         | 7,965,300.00   | 5,855,000.00   | (2,110,300.00)  | 73.5  |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                       | 892,700.00     | 860,200.00     | (32,500.00)     | 96.4  |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс              | 969,400.00     | 731,450.00     | (237,950.00)    | 75.5  |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 3,200,000.00   | 3,127,900.00   | (72,100.00)     | 97.7  |
| 210602 | Тавилга                                                  | 500,000.00     | 500,000.00     | -               | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл                             | 1,200,000.00   | 1,127,900.00   | (72,100.00)     | 94.0  |
| 210604 | Урсгал засвар                                            | 1,500,000.00   | 1,500,000.00   | -               | 100.0 |
| 2107   | Томилолт, зочны зардал                                   | 1,657,000.00   | 1,290,700.00   | (366,300.00)    | 77.9  |
| 210702 | Дотоод албан томилолт                                    | 1,657,000.00   | 1,290,700.00   | (366,300.00)    | 77.9  |
| 2108   | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,561,100.00   | 1,215,500.00   | (345,600.00)    | 77.9  |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                 | 450,000.00     | 450,000.00     | -               | 100.0 |

|        |                                                |                       |                       |                        |              |
|--------|------------------------------------------------|-----------------------|-----------------------|------------------------|--------------|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар                     | 183,600.00            | 64,500.00             | (119,100.00)           | 35.1         |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                | 516,000.00            | 516,000.00            | -                      | 100.0        |
| 210807 | Газрын төлбөр                                  | 185,000.00            | 185,000.00            | -                      | 100.0        |
| 213    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                        | <b>200,000.00</b>     | <b>200,000.00</b>     | <b>-</b>               | <b>100.0</b> |
| 2132   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                  | <b>200,000.00</b>     | <b>200,000.00</b>     | <b>-</b>               | <b>100.0</b> |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 200,000.00            | 200,000.00            | -                      | 100.0        |
| III    | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>          | <b>145,100,800.00</b> | <b>121,529,458.59</b> | <b>(23,571,341.41)</b> | <b>83.8</b>  |
| 32     | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>          | <b>145,100,800.00</b> | <b>121,529,458.59</b> | <b>(23,571,341.41)</b> | <b>83.8</b>  |
| 320001 | Орон нутгийн төсвөөс                           | 145,100,800.00        | 121,529,458.59        | (23,571,341.41)        | 83.8         |
| 62     | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                        | <b>3</b>              | <b>3.00</b>           | <b>-</b>               | <b>100.0</b> |
| 620001 | Удирдах ажилтан                                | 1                     | 1.00                  | -                      | 100.0        |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан                              | 2                     | 2.00                  | -                      | 100.0        |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй болно.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Сум дундын ойн анги нь эрхэм зорилгоо ойн эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойн хомсдол, доройтлыг зогсоож, ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх, нөөцийг зохистой, иж бүрэн ашиглахад чиглэсэн ойн тогтвортой менежментийг бий болгох, ойн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх гэж тодорхойлсон байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Ойн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2024 оны 04 сарын 01-ний өдрийн "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" А52 дугаар тушаал;
- Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоол;

- Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоол

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Сум дундын ойн анги нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,662.2 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл  | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт  |
|----------------------------------------------|-----------------|-----------------|-----------|
| Б                                            | 1               | 2               | 3=2-1     |
| Мөнгөн хөрөнгө                               | 0.0             | 0.0             | 0.0       |
| Авлага                                       | 0.0             | 0.0             | 0.0       |
| Бараа материал                               | 21,210.0        | 18,139.3        | (3,070.7) |
| Үндсэн хөрөнгө                               | 27,549.6        | 32,282.5        | 4,732.9   |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>48,759.6</b> | <b>50,421.8</b> | 1,662.2   |
| Өр төлбөр                                    | 0.0             | 0.0             | 0.0       |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 48,759.6        | 50,421.8        | 1,662.2   |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>48,759.6</b> | <b>50,421.8</b> | 1,662.2   |

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 18,139.3 мянган төгрөг болж 3,070.7 мянган төгрөгөөр буурсан байна. Тодруулбал төсвийн хөрөнгөөр 9,653.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 4,215.0 мянган төгрөгийн хашааны шон, тор, хүлэмжийн нийлэг хальсийг актлаж, 8,508.9 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 4,732.9 мянган төгрөгөөр өссөн байна. Тодруулбал тайлант онд төсвийн хөрөнгөөр 500,0 мянган төгрөгөөр 2 ширхэг сандал худалдан авч, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02 өдрийн А/35 тоот тушаалаар 4,371.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглах жилийг шинэчлэн тогтоож 1,726,3 мянган төгрөгөөр орлого авсан, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 24 тоот тогтоолоор 2000м2 газар эзэмших эрхийн үнэлгээг 12,000.0 мянган төгрөгөөр үнэлж, нийт 13,726.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэн, тайлант хугацаанд 9,493.4 мянган төгрөгийн элэгдэл тооцож, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 50,421.8 мянган төгрөг болж 1,662.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт төсвийн санхүүжилт төсвийн гүйцэтгэл гараагүй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр 91,046.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 54,054.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 145,100.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд батлагдсан төсвийг 145,100.8 мянган төгрөг болгон нэмэгдүүлж тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны зардлыг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 145,100.8 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 122,848.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаандаа 121,529.5 мянган төгрөгийг зарцуулан, 1.318.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| /мянган төгрөгөөр/ |                                                 |                  |                  |                   |             |
|--------------------|-------------------------------------------------|------------------|------------------|-------------------|-------------|
| д/д                | Хөтөлбөр, арга хэмжээ                           | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл        | Зөрүү             | Биелэлт     |
| 1                  | <b>71403-Ойжуулалт</b>                          | <b>145,100.8</b> | <b>121,529.5</b> | <b>(23,577.6)</b> | <b>83.8</b> |
| 1.1                | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал             | 138,343.9        | 116,202.5        | (22,141.5)        | 96.6        |
| 1.2                | 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал   | 200.0            | 200.0            | 0.0               | 100.0       |
| 1.3                | 80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал | 6,556.9          | 5,127.0          | (1,429.9)         | 0.8         |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт төсвийн тайлан байхгүй болно.

#### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй болно.

#### Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Сум дундын ойн ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк ом аудит” ХХК-ийн аудитор А.Батболд гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг захирал Б.Жаргалсайхан дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн

Дархан-Уул аймгийн Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардлын 74,500.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,490.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд алдаа зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 831.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт |       | Биелэлт |       |      |
|----------|------------------------|-------|---------|-------|------|
|          | Тоо                    | Дүн   | Тоо     | Дүн   | Хувь |
| Зөвлөмж  | 2                      | 831.5 | 2       | 831.5 | 100  |

|          |   |       |   |       |     |
|----------|---|-------|---|-------|-----|
| Нийт дүн | 2 | 831.5 | 2 | 831.5 | 100 |
|----------|---|-------|---|-------|-----|

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 666,7 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

##### 5.1 Төлбөрийн акт

Тайлант онд төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

##### 5.2 Албан шаардлага

##### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.  
Үүнд:

1. Хавсран ажиллаж буй ажилтанд үндсэн ажилтай давхардуулан ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал бодож олгосон нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д " хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай 56 дугаар зүйлийн 56.1 - т "Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно, 56.2-т тухайн ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

#### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                    | Нийт зөрчил |       | Үүнээс        |     |                 |     |         |       |                                      |                     |                                                 |     |
|-------------------------------------------------------|-------------|-------|---------------|-----|-----------------|-----|---------|-------|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|-----|
|                                                       |             |       | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |       | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|                                                       | Тоо         | Дүн   | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн   | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн |
| Хавсран ажилтанд давхардуулан нэмэгдэл цалин олгосон. | 1           | 666.7 |               |     |                 |     | 1       | 666.7 |                                      |                     |                                                 |     |
| Дүн                                                   | 1           | 666.7 |               |     |                 |     | 1       | 666.7 |                                      |                     |                                                 |     |